Гар тээшинд авч явах зөвшөөрөгдөх шингэн

Шингэн:

Шингэн гэдэг ойлголтонд дараах зүйлсийг хамруулна. Ус, ундаа шөл, жүүс, жимсний чанамал, зутан, соус, нухаш, шүдний оо, шөлтэй хоол, тос, бие угаах шингэн, гоо сайхны бүтээгдэхүүн, үнэртэй ус, шүршдэг шингэн, будаг, үсний болон бусад гель, шахсан хийтэй сав, сахлын болон бусад хөөс, дезодорант, хатуу шингэний холимог, сормуусны будаг, уруул өнгөлөгч, гавар болон тасалгааны температурт байхдаа эдгээртэй ижил шинж чанар бүхий бусад зүйл.



- ✓ Шингэнтэй савыг нийт багтаамж нь 1 литрээс ихгүйг зөвшөөрнө. Тунгалаг гялгар уутанд савалж гар тээшинд тээвэрлэнэ.
- ✓ Тээвэрлэлтийн явцад гялгар уутны амыг бүрэн хаасан байна.



- ✓ Шингэн нь хэмжээгээрээ 100мл-ээс бага боловч 100мл-ээс их багтаамж бүхий савтай бол гар тээшинд тээвэрлэхийг хориглоно.
- ✓ 100мл-ээс их эзэлхүүнтэй хоосон савыг гар тээшинд тээвэрлэхийг зөвшөөрнө.
- ✓ Гар тээшинд тээвэрлэх шингэнийг тус бүр нь 100мл-ээс ихгүй хэмжээтэйгээр савласан байна.

